

## Далан зургадугаар зүйл

Хэрэв шилжуулэн өгөхгүй бол шилжуулэн өгөх тухай шаардлагыг хулээн авч байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээд уг шаардлагыг явуулж байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдэд шилжуулэн өгөхгүй тухайгаа болон татгалзаж байгаа шалтгааныг мэдэгдэнэ.

## Далан долдугаар зүйл

Тодорхой нөхцөлтэйгээр шилжуулэн  
өгөх

Шилжуулэн өгөхийг шааодаж байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн шуух хэрэв хэргийг эчнээгээр таслан шийдвэрлэсэн байвал шаардлага хулээн авч байгаа Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээд уг хэргийг дахин өөрий нь оролцоотойгоор шуун таслах тодорхой нөхиөлтэйгээр гэмт этгээдийг шилжуулэн өгч болно.

## Далан наймдугаар зүйл

Харилцах журам

Эруугийн хэрэг уусгэх буюу гэмт этгээдийг шилжуулэн өгөх асуудлаар Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн Ерөнхий буюу Улсын Прокурор бие биетэйгээ харилцана.

## Далан есдүгээр зүйл

Шилжуулэн өгөх тухай шаардлага

I. Цагдан хорих тухай тогтоол, гэмт хэрэг гарсан байдлын тодорхойлолт, уг этгээдийг тэр гэмт хэрэгт лавтай сэжиглэх үндэс бүхий нотлох баримтын тодорхойлолт, хэрэгт ял ноогдуулах хуулийн зүйл анги, хэрэв гэмт хэргийн улмаас эд материалын хохирол учирсан бол тууний хэмжээг тус тус гэмт этгээдийг шилжуулэн өгөх тухай шаардлагад хавсаргах хэрэгтэй.